



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/701

Арвайхээр

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
бусдад шилжүүлэх тухай**


Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын 5 дугаар баг барилгачдын гудамж барилга-5 тоотод байрлах “Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар”-ын (9044132) эзэмшлийн төрийн үйлчилгээний зориулалттай 6977м<sup>2</sup> газраас уурын зуухны барилга байрлах 376м<sup>2</sup> газрыг Загдгочоогийн Балданнямд (йю75102913) зориулалтын дагуу 48 жил 9 сар, өрхийн эрүүл мэндийн төв байрлах 855м<sup>2</sup> газрыг Уянсэтгэл өрхийн эрүүл мэндийн төвд зориулалтын дагуу 48 жил 9 сар хугацаатайгаар тус тус газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, хуулийн этгээдтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2007 оны 95 дүгээр захирамжийн хавсралт 6 дахь хэсэг, 2016 оны 311 дүгээр захирамжийн хавсралтын Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газартай холбогдох 34 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101527